

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: ДНБ, УЛСЫН ТӨСӨВ, ГАДААД ХУДАЛДАА, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ


Эдийн засгийн өсөлт 7%-д хүрэв.

2014 оны 3-р улирлын байдлаар ДНБ-ны хэмжээ 2010 оны зэрэгцүүлэх үнээр 11.1 их наяд төгрөг болж өнгөрсөн жилийн мөн үеэс 7 хувиар өссөн. Уг өсөлтөнд аж үйлдвэр, барилгын салбар 22.2%, ХАА-н салбар 14%-иар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Энэ онд эдийн засгийн өсөлт ийнхүү удаашралтай байгаа нь ДНБ-ны 20 гаруй хувийг бүрдүүлдэг уул уурхайн салбар зогсонги байдалтай байгаатай холбоотой.




11 сарын төсвийн алдагдал өмнөх сараас 114 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 393 тэрбум төгрөгт хүрэв.

2014 оны арван нэгдүгээр сарын байдлаар засгийн газрын нийт зарлага 5.71 их наяд төгрөг, нийт орлого 5.32 их наяд төгрөгт хүрсэн байна. Өмнөх онтой харьцуулахад арван нэгдүгээр сард төсвийн алдагдал 136 хувиар илүү байна. Төсвийн нийт орлого энэ сард 465 тэрбум төгрөг буюу 13.6% -иар буурсан бол нийт зарлага 580 тэрбум төгрөг буюу 7.2% -иар нэмэгдсэн байна. Орлого ингээ нэмэгдэхэд ААНОАТ, НӨТ, бусад татварууд 33 хувиар нэмэгджээ.



11 сард гадаад худалдааны ашиг 358 сая ам.доллар болж нэмэгджээ.

Арваннэгдүгээр сард бараа худалдааны нийт бараа эргэлт 10.02 тэрбум ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 3.2 хувиар нэмэгдсэн байна. Экспорт 5.19 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн жилтэй харьцуулахад 34.4 хувиар өссөн бол импорт 4.83 тэрбум ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 17.5 хувиар буурчээ. Буурсан гол шалтгаан нь ашигт малтмалын экспорт 37.9 хувиар буурч, импортод эзлэх тээврийн хэрэгслийн импорт, машин, цахилгаан бараа, эрдэс бүтээгдэхүүнийн хэмжээ тус тус 40.4%, 28.3%, 14.8%-иар буурчээ.




11 сард валютын ханш 1.6 хувиар суларч нэг ам. долларын ханш 1,879.8 төгрөг болов.

11 сарын дундаж нэг ам.долларын ханш 1,879.8 төгрөгт хүрч өмнөх сараас 1.6 хувь буюу 29.86 төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар, оны эхнээс 12.25 төгрөгөөр өсөөд байна. Гадаад валютын улсын албан нөөц арван нэгдүгээр сарын байдлаар 1,398 сая ам.доллар буюу өмнөх сараас 9.4 хувиар, оны эхнээс 37.8 хувиар, өмнөх оны мөн үеэс 41.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



2014 он гарснаар инфляцийн түвшин дөрвөн сар дараалан бууж 11.5% боллоо.


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд энэ сард өмнөх сарынхаас 0.7 хувь, оны эхнээс 10.1 хувь, өмнөх оны мөн үеэс 11.5 хувиар өслөө. Өмнөх сарынхаас 0.7 хувиар өсөхөд орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 2.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 1.4 хувиар өссөн бол хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн 0.7 хувийн өсөлтийн 0.3 нэгж (35.9 хувь) нь орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлтөөс, 0.2 нэгж (33.9 хувь) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийнхээс голлон шалтгаалсан байна.



САНХҮҮГИЙН САЛБАР: МӨНГӨ, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ

Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 0.4 хувь буурлаа

Энэ сард мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 0.4 хувиар буурч 9.9 их наяд төгрөг, гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өмнөх сараас 5.3 хувиар буурч 769 тэрбум төгрөг болжээ. Улмаар М2 мөнгөний нийлүүлэлтэнд эзлэх гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ 7.7% болж буурсан байна. Монголбанкнаас мөнгөний хатуу бодлого явуулж байгаа бөгөөд бодлогоор мөнгөний нийлүүлтийг бууруулсаар байна




Валютын хадгаламж өмнөх сараас 10.9 хувиар өсөв.

Өнгөрсөн сартай харьцуулахад Төгрөгийн хадгаламж 1.7 хувь буурч 4.9 их наяд төгрөг, валютын хадгаламж 10.9 хувиар өсөж 1.9 их наяд төгрөг болж нийт хадгаламж хэмжээ 6.8 их наяд төгрөг болов. Энэ нь өмнөх сараас 1.47 хувиар өссөн дүн юм. Валютын хадгаламж ийнхүү хурдацтай өсөж байгаа нь төгрөгийн ханшны сулрал болон эдийн засгийн тогтворгүй байдлаас үүдэлтэй бөгөөд цаашид нэмэгдэх хандлагатай байна.



Чанаргүй зээлийн хэмжээ 14 сая төгрөгөөр өсөв.

Энэ сарын байдлаар нийт зээл 12,6 тэр бум төгрөг болж өмнөх сараас 1.4 хувиар буурчээ. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 2.3 хувиар нэмэгдэж 620 сая төгрөгт хүрсэн байна. Нийт зээлийн хэмжээ буурснаар нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өсөж байгаа ч өмнөх сарын дүнгээс 14 сая төгрөгөөр нэмэгджээ.



Эх сурвалж: УСХ, МБ

Сарын онцлох үйл явдал

11 сарын 8 Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж АПЕК-ийн дээд түвшний уулзалтад оролцсон Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа буюу АПЕК-ийн дээд түвшний уулзалтын хүрээнд Бээжин хотноо болсон “Дэд бүтцийн түншлэлийн харилцааг бэхжүүлэх нь” яриа хэлэлцээнд БНХАУ-ын даргын урилгаар оролцож,

БНХАУ-ын дарга Си Зиньпин, БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Жан Дзэян нартай уулзаж, “Түншлэлийн яриа хэлэлцээ” сэдэвт форумд үг хэллээ.

11 сарын 18 Монгол Улсын 2015 оны улсын төсвийг батлав.

11 сарын 21 Монгол улсын шинэ Ерөнхий сайдаар Чимэдийн Сайханбилэг сонгогдов.

Хураангуй

2014 оны арван нэгдүгээр сарын байдлаар засгийн газрын нийт зарлага 5.71 их наяд төгрөг, нийт орлого 5.32 их наяд төгрөгт хүрсэн байна. Өмнөх онтой харьцуулахад арван нэгдүгээр сард төсвийн алдагдал 136 хувиар илүү байна. Төсвийн нийт орлого энэ сард 465 тэрбум төгрөг буюу 13.6% -иар буурсан бол нийт зарлага 580 тэрбум төгрөг буюу 7.2% -иар нэмэгдсэн байна. Төсвийн орлого буурсан хэдий ч орлогод эзлэх аж ахуй нэгжийн орлогын албан татвар, НӨАТ-ийн татвар гэх мэт татварууд 33 хувиар нэмэгджээ. Энэ сард бараа үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба шилжүүлгийн зардлууд (39%, 31%, 25% тус тус) өссөнөөр нийт урсгал зардлыг 11.3%-иар өсгөжээ. Мөн хөрөнгийн зардал энэ сард 14%-иар өссөн нь төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх гол үзүүлэлт болж өглөө.

Арваннэгдүгээр сард бараа худалдааны нийт бараа эргэлт 10.02 тэрбум ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 3.2 хувиар нэмэгдсэн. Экспорт 5.19 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн жилтэй харьцуулахад 34.4 хувиар өссөн бол импорт 4.83 тэрбум ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 17.5 хувиар буурчээ. Буурсан гол шалтгаан нь ашигт малтмалын экспорт 37.9 хувиар буурч, импортод эзлэх тээврийн хэрэгслийн импорт, машин, цахилгаан бараа, эрдэс бүтээгдэхүүнийн хэмжээ тус тус 40.4%, 28.3%, 14.8%-иар буурчээ.

Нэг ам.долларын ханш 1,879.8 төгрөгт хүрч өмнөх сараас 1.6 хувь буюу 29.86 төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар, оны эхнээс 12.25 төгрөгөөр өсөөд байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд энэ сард өмнөх сарынхаас 0.7 хувь, оны эхнээс 10.1 хувь, өмнөх оны мөн үеэс 11.5 хувиар өслөө. Өсөлтөд орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 2.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 1.4 хувиар өссөн бол хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн 0.7 хувийн өсөлтийн 0.3 нэгж (35.9 хувь) нь орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлтөөс, 0.2 нэгж (33.9 хувь) нь хувцас, бөс бараа, гутлын

бүлгийнхээс голлон шалтгаалсан байна.

Өнгөрсөн сараас төгрөгийн хадгаламж 1.7% буурч 4.9 их наяд төгрөг, валютын хадгаламж 10.9% өсөж 1.9 их наяд төгрөг болж нийт хадгаламж 6.8 их наяд төгрөг болсноор өмнөх сараас 1.47 хувиар өсөв. Валютын хадгаламж ийнхүү хурдацтай өсөж байгаа нь төгрөгийн ханшны сулрал болон эдийн засгийн тогтворгүй байдлаас үүдэлтэй бөгөөд цаашид нэмэгдэх хандлагатай байна



САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2014 оны XI сар



САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2014 оны XI сар